

# СТАТИСТИКИЙН ТАНИЛЦУУЛГА



**Дүүргийн эдийн  
засаг, нийгмийн  
байдал**

**2017 он  
3-р сар**

## АГУУЛГА

Хуудасны  
тоо

1. ДҮҮРГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2
2. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	3
3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	6
4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	7
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	8
6. НИЙГМИЙН ДААТГАЛ	10
7. НИЙГМИЙН ХАЛАМЖ	10
8. УЛААН ЗАГАЛМАЙ	11
9. АЖ АХУЙН НЭГЖ	11
10. АЖ ҮЙЛДВЭР	12
11. ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	13
12. ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ	14
13. ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ	14
14. ЗАХИРГААНЫ МЭДЭЭ	15
15. ГЭМТ ХЭРЭГ	15
16. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ЗӨРЧИЛ	15
17. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ ГАМШИГ	15
18. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ	15
19. ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ	16

## Хүснэгт 1. Дүүргийн үндсэн үзүүлэлт. 2017 оны 3 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он
Суурин хүн ам /жилийн эцэст/	Хүн	154819	158014
Төрөлт	Тоо	978	860
Шинээр төрсөн хүүхэд	Тоо	997	860
Нас баралт	Тоо	190	216
Халдварт өвчин	Тоо	1423	682
Ажилгүйчүүд	Хүн	3287	2716
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	1013	1012
Дүүргийн төсвийн орлого	Сая төгрөг	15567.0	26847.4
Дүүргийн төсвийн зарлага	Сая төгрөг	13998.0	16896.4
Валютын ханш	1US\$=₮	1974.5	2423.16




## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 3-р сарын Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 хувиар, 2016 оны жилийн эцэстэй харьцуулахад 3.4 хувиар, өмнөх сартай харьцуулахад 1.3 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Хэрэглээний үнийн индекс

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2015.03}{2014.03}$	$\frac{2016.03}{2015.03}$	$\frac{2017.03}{2016.03}$	$\frac{2017.03}{2017.02}$
Ерөнхий индекс	101.1	102.3	103.4	101.3
Хүнсний бараа, ундаа, ус	97.0	103.5	111.3	104.7
Согтууруулах ундаа, тамхи	102.1	102.6	100.2	100.0
Хувцас, бөс бараа	101.1	98.2	99.3	99.1
Орон сууц, ус, түлш, цахилгаан	98.6	104.9	101.9	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	104.0	100.0	98.9	98.6
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	108.2	106.1	102.0	100.7
Тээвэр	97.4	101.1	100.5	100.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.1	99.9	99.9	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	100.3	97.8	98.3	99.3
Боловсролын үйлчилгээ	123.6	102.6	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	101.8	101.0	99.8	100.6
Бусад бараа, үйлчилгээ	103.1	105.0	101.5	100.6

Зураг 1. Хэрэглээний үнийн өсөлт сараар



Хэрэглээний үнийн индекс 2017 оны 3-р сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 3.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 11.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 1.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бүлгийн үнэ 0.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 2.0 хувь, бусад бараа, үйлчилгээ 1.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.


Хүснэгт 3. Бараа бүтээгдэхүүний дундаж үнэ, төгрөг

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2015.03	2016.03	2017.03
Алтан тариа 1-р зэрэг	кг	1010	1065	1000
Атар талх	ш	1065	1150	1165
Цагаан будаа	кг	2350	2510	2625
Шар будаа	кг	1795	1695	1745
Хонины мах /ястай/	кг	7745	6755	7130
Үхрийн мах /ястай/	кг	8335	7690	8195
Адууны мах	Кг	5775	4875	4925
Тахианы гуя	кг	6600	6500	6500
Сүү задгай	л	1400	1400	1300
Цөцгийн тос /Сүү ХХК/	кг	3005	3255	3290
Өндөг	ш	305	285	335
Ургамлын тос /Янта/	л	2967	3300	3380
Алим, кг	кг	4245	4035	4250
Банан, шар	кг	4500	5000	4500
Төмс	кг	1245	7075	735
Лууван	кг	1375	1970	1025
Сонгино	кг	1195	1310	1290
Элсэн чихэр	кг	1730	1785	2450
Цэвэр усны үнэ тоолуургүй 1хүний	хүн	4705.8	4705.8	4705.8
Эдийн саван ОК	ш	600	700	750
Угаалгын нунтаг "ОМО"	ш	800	850	1100
Аяга, таваг угаагч шингэн, "Fairy"	ш	3600	4050	4300


Зураг 2. Алтан тариа дээд гурил, атар талхны үнэ, 2013-2017 он



Зураг 3. Нэг кг хонь, үхрийн махны дундаж үнэ, 2012-2017 он



Зураг 4. Нэг кг лууван, төмсний дундаж үнэ, 2012-2017 он



Зураг 5. Нэг кг сонгино, байцааны дундаж үнэ, 2012-2017 он



Зураг 6. Шатахууны үнэ, 2012-2017 он





## ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

**Төсвийн орлого:** Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2017 оны 3 дугаар сарын байдлаар 26847.4 сая төгрөг, нийт зарлага цэвэр зээлийн дүн 16896.4 сая төгрөг болж, орон нутгийн төсвийн нийт тэнцэл 9951.0 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан байна.

Орон нутгийн нийт төсвийн төлөвлөгөөний биелэлтийг нэр тус бүрээр нь доорх хүснэгтэнд харуулав.


Хүснэгт 4. Төсвийн урсгал орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт орлогын дүн	21,399,791.6	26,847,373.5	5,447,581.9	25.5
Урсгал орлого	11,589,918.1	16,745,850.6	5,155,932.5	44.5
1. Татварын орлого	11,395,768.1	15,626,820.4	4,231,052.3	37.1
Орлогын албан татвар	3,002,935.8	3,244,272.0	241,336.2	8.0
Өмчийн татвар	5,325.0	6,058.3	733.3	0.1
Бусад татвар	8,387,507.3	12,376,490.1	3,988,982.8	47.6
2.Татварын бус орлого	194,150.0	1,480,553.3	1,286,403.3	662.6
Тусламжийн орлого	9,809,873.5	9,739,999.8	-69,873.7	0.7

Төсвийн төлөвлөгөөний биелэлт тусламжийн орлогоос бусад нэр төрөл дээр төлөвлөснөөс давж бүрдсэн байна.

**Төсвийн зарлага:** Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 2017 оны 3 дугаар сарын байдлаар 16896.4 сая төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс 8276.1 сая төгрөгөөр буюу 32.9 хувиар төсвийн зардлыг хэмнэсэн байна.

Зураг 7. Төсвийн зардал



Төсвийн нийт зарлагын 31.5 хувийг цалин хөлс, 3.5 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 41.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 22.8 хувийг татаас, 0.9 хувийг хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. Төсвийн зарлага


Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	25172490.8	16896394.3	-8276096.5	32.9
А. Урсгал зардлын дүн	22695727.4	16745850.6	-5949876.8	26.2
1. Бараа үйлчилгээний зардал	17972606.8	12888343.8	-5084263.0	28.3
1.1 Цалин хөлс	5898484.1	5328204.4	-570279.7	9.7
1.2 НДШ хураамж	656434.5	588044.0	-68390.5	10.4
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	11417688.2	6972095.4	-4445592.8	38.9
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	4723120.6	3857506.8	-865613.8	18.3
3.1 Татаас	4723120.6	3857506.8	-865613.8	18.3
3.2 Урсгал шилжүүлэг	0.0	0.0	0.0	-
Б. Хөрөнгийн зардал	2476763.4	150543.7	-2326219.7	93.9
1. Хөрөнгө оруулалт	2476763.4	150543.7	-2326219.7	93.9



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

Хөдөлмөрийн хэлтсийн 2017 оны 3-р сарын мэдээгээр ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй 2716 иргэн бүртгүүлсэн байна. Нийт ажил хайж байгаа эмэгтэйчүүд 1301 буюу 47.9 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 18 буюу 0.7 хувь байна. Насны бүлгээр авч үзвэл нийт ажил хайж байгаа иргэдийн 254 буюу 9.3 хувь нь 15-24 насны, 1137 буюу 41.9 хувь нь 25-34 насны, 701 буюу 25.8 хувь нь 35-44 насны, 480 буюу 17.7 хувь нь 45-54 насны, 144 буюу 5.3 хувь нь 55 дээш насны хүмүүс байна.

Зураг 8. Ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн тоо боловсролын түвшингээр







## ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар дүүргийн хэмжээнд 860 эх амаржиж, 860 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эхийн тоо 118 буюу 12.1 хувь, амьд төрсөн хүүхэд 137 буюу 13.7 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 6. Эмнэлгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт		2016 он	2017 он	Зөрүү	Хувь
Нийт үзлэг		189486	179375	-10111	5.3
Үүнээс:	Урьдчилан сэргийлэх	67979	67473	-506	0.7
	Амбулаторид	58949	53334	-5615	9.5
	Диспансерийн хяналт	24231	21728	-2503	10.3
	Гэрийн үзлэг	37068	30130	-6938	18.7
	Гэрийн дуудлагын үзлэг	1259	6710	5451	432.9
Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг		66438	59997	-6441	9.7
Өрхийн эмчийн үзлэг		123048	119378	-3670	3.0
Бүртгэгдсэн өвчлөл		12734	15037	2303	18.1
Үүнээс:	Шинэ	8422	9675	1253	14.9
	Хуучин	4312	5362	1050	24.4
Бүртгэгдсэн хорт хавдар		18	17	-1	5.6
Осол гэмтэл		308	14	-294	95.5
Хэвтсэн өвчтөн		2927	2277	-650	22.2
Эмнэлгийн нас баралт		14	19	5	35.7
Хоног болоогүй нас баралт		2	2	0	-
Эмчлэгдсэн өвчтөн		2893	2322	-571	19.7

2017 он гарсаар 216 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 26 хүнээр буюу 13.7 хувиар өссөн байна. Нийт нас баралтын дотор нялхсын эндэгдэл 10 буюу 4.6 хувь, 1-5 насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй байна. Нялхсын эндэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 50.0 хувиар буурсан байна. 2017 оны эхний улирлын байдлаар 179.4 мянган хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 10.1 мянган хүн буюу 5.3 хувиар, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний хүний тоо 2277 болж өмнөх оны мөн үеэс 22.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 9. Нийт үзлэг, төрлөөр



Хүснэгт 7. Халдварт өвчин

Үзүүлэлт	2016 он	2017 он	Зөрүү	Хувь
Халдварт өвчин	1423	682	-741	52.1
Гепатит	8	10	2	25.0
Цусан суулга	33	48	15	45.5
Сальмоннез	1	6	5	500.0
Хоолны хордлого	0	0	0	-
Менингит	0	1	1	-
Салхин цэцэг	90	165	75	83.3
Гахайн хавдар	6	3	-3	50.0
Улаан эсэргэнэ	27	32	5	18.5
Ёлом	1	3	2	200.0
Улаан бурхан	892	0	-892	100.0
Улаанууд	0	0	0	-
Бруцеллөз	0	2	2	-
Гар, хөл, ам	86	119	33	38.4
Тэмбүү	134	109	-25	18.7
Төрөлхийн тэмбүү	1	0	-1	100.0
Заг хүйтэн	53	38	-15	28.3
Трихомониаз	14	45	31	221.4
Мөөгөнцөр	7	11	4	57.1
Сүрьеэ	68	67	-1	1.5
Бусад	3	3	0	-

Халдварт өвчин 2017 оны эхний сарын байдлаар 682 бүртгэгдсэн нь өмнөх оноос 52.1 хувиар буурсан нь улаан бурхан өвчний бууралттай холбоотой байна. Бэлгийн замын халдварт өвчин нийт халдварт өвчний 29.8 хувийг эзэлж байна. БЗХӨ өнгөрсөн оны мөн үеэс 2.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



## НИЙГМИЙН ДААТГАЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны 3-р сард төсвийн 198 байгууллагын 17712 албан хаагчид, хувийн хэвшлийн 3226 аж ахуйн нэгжийн 57924 албан хаагчид, сайн дурын 9292 иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. Эрүүл мэндийн даатгалд 39621 иргэн хамрагдсан. Үүнээс төр эрүүл мэндийн даатгалыг хариуцсан даатгуулагч 32743 байна.

### Хүснэгт 8. Тэтгэвэр олголт

	Хүний тоо	Олгосон тэтгэмж	
		Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Өндөр настан	15801	5733.1	5605.0
Тахир дутуу	3071	812.9	698.9
Тэжээгчээ алдсан	960	226.4	223.0
Дүн	19832	6772.4	6526.9



## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны 3-р сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 14.8 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 2.0 хувийг хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлогод тус тус хуваарилсан байна.

### Хүснэгт 9. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, сая.төг

Үзүүлэлт	Үнийн дүн
Нийгмийн халамжийн сангийн орлого	4934.8
1. Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн төсвийн санхүүжилт	2569.2
a) Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	730.3
b) Алдарт эхийн одонгийн тусламж	1100.0
c) Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	639.0
d) ОНОТХҮ үйлчилгээний санхүүжилтын орлого	-
e) Хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлого	99.9
2. Нийгмийн халамжийн сан	2365.6
a) Төсвийн санхүүжилтын орлого	2362.9
b) Бусад орлого	
3. Хүүгийн орлого	2.7
Зарлагын нийт дүн	3902.6
1. Нийгмийн халамжийн сан	2230.7
2. Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	458.1
3. Алдарт эхийн одонгийн тусламж	1017.5
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	101.9
5. Хүнс тэжээлийн хөтөлбөр	94.4
6. ОНОТХ. үйлчилгээ	-

Нийгмийн халамжийн сан нь 2570 хүнд халамжийн тэтгэвэр, 3007 хүнд асаргааны мөнгөн тэтгэмж, 2851 хүнд ахмад настаны хөнгөлөлт тусламж, 4659 хүнд жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн мөнгөн тэтгэмжийг зарцуулсан байна.



### УЛААН ЗАГАЛМАЙН ЧИГЛЭЛЭЭР

Дүүргийн “Улаан загалмайн хороо” 2017 оны 3-р сард нийт 37 хүнд 474.7 мян.төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 222 хүн, 3.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүн

зардалаар

Үзүүлэлт	2016 он 03-р сар			2017 он 03-р сар		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг /
Халамж үйлчилгээ	6	259	3687500	7	37	474700
Анхны тусламжийн сургалт	19	327		3	111	
Гамшгийн тусламж	2	6	217480	1	7	87800
Донорын өдөрлөг	1	35		2	286	
Дүн	28	627	3904980	13	441	562500

Мөн анхы тусламжийн 3 удаагийн сургалт зохион байгуулж, сургалтанд нийт 111 иргэн, донорын өдөрлөг арга хэмжээг 2 удаа зохион байгуулж 286 иргэнийг хамруулсан байна.



### АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар татварын хэлтсийн мэдээлэл боловсруулалтын санд бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 16186 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 хувиар буюу 585 аж ахуй нэгж байгууллагаар нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагын 77.1 хувь буюу 12475 байгууллага нь ХХК байна. Он гарсаар 317 аж ахуйн нэгж байгууллага нэмэгдэж, 3 байгууллага сангаас хасагдсан байна.

Хүснэгт 11. Аж ахуй нэгж байгууллагын тоо

ААНБ-ын төрөл	ААНБ-ын хариуцлагын хэлбэр	2015.03	2016.03	2017.03
ААН	ХК	9	11	14
	ХХК	11097	12148	12475
	ББН	115	130	129
	ЗБН	85	90	96
	ХХН	30	38	52
	Хоршоо	55	55	48
	Хадгаламж зээлийн хоршоо	67	69	60
	Төрийн өмчит үйлдвэрийн газар	30	34	33
	ОНӨҮГ	7	11	13
	Салбар	725	712	747
	Төлөөлөгчийн газар	8	17	24
	Төлөөний газар	1	2	4
	Боловсролын сургалтын байгууллага		1	1
	Нийт	12229	13318	13696
Төсөв болон ТББ	Төсөвт байгууллага	263	278	299
	Төрийн бус байгууллага	1427	1649	1826
	Шашны байгууллага	39	42	42
	Сан	87	107	114
	Боловсролын сургалтын байгууллага			1
	Олон нийтийн байгууллага	198	207	208
	Нийт	2014	2283	2490
Бүгд	14243	15601	16186	



**АЖ ҮЙЛДВЭР**


Аж үйдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2017 оны 3 сард 1350.5 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 44.6 хувь буюу 601.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь хувцас үйлдвэрлэл 21.5 хувь, хүнс үйлдвэрлэл 81.4 хувь, хэвлэлийн үйлдвэрлэл 37.8 хувь, бусад үйлдвэрлэл 44.4 хувиар тус тус өсөхөд нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 12. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /сая.төг/

Салбар		2016.03	2017.03	Өсөлт, бууралт	Зөрүү
Бүгд		748.7	1350.5	44.6	601.8
Үүнээс:	Хувцас үйлдвэрлэл	298.1	379.9	21.5	81.8
	Хүнс үйлдвэрлэл	59.9	321.8	81.4	261.9
	Хэвлэлийн үйлдвэрлэл	283.1	455.4	37.8	172.3
	Бусад үйлдвэрлэл	107.6	193.4	44.4	85.8

2017 оны 3 дугаар сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн 28.1 хувийг хувцас үйлдвэрлэл, 23.8 хувийг хүнс үйлдвэрлэл, 33.8 хувийг хэвлэлийн үйлдвэрлэл, 14.3 хувийг боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Зураг 10. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн



## ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

### Иргэний бүртгэлийн үйлчилгээ:

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2017 оны 3-р сарын байдлаар иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээг 3039 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар, өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 13. Иргэний бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт		2016.03	2017.03
<b>Нийт</b>		<b>2861</b>	<b>3039</b>
Шинэ төрсөн		275	291
Гэрлэлт		70	74
Гэр бүл цуцлалт		24	20
Хүүхэд үрчлэлт		2	5
Эцэг тогтоосон		130	153
Овог, нэр өөрчлөх		9	27
Иргэний үнэмлэх олголт	16 нас хүрч шинээр авсан	147	185
	дахин олголт	395	491
Шилжилт хөдөлгөөн	шилжин ирсэн	821	693
	шилжин явсан	988	1100

### Эд хөрөнгийн бүртгэл үйлчилгээ:

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2017 оны 3-р сарын байдлаар 1443 иргэн, аж ахуй нэгж байгууллагад эд хөрөнгийн бүртгэлийн 5 төрлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Хүснэгт 14. Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт	Үйлчлүүлсэн тоо			Үйлчилгээний хөлс /мян.төг/		
	Нийт	Газар	Газраас бусад	Нийт	Газар	Газраас бусад
Нийт	1443	460	983	20899.1	11376.3	9522.8
Анхны бүртгэл	109	46	63	67.9	50.0	17.9
Өмчлөх эрх шилжих гэрээ	186	71	115	4488.0	1700.0	2788.0
Барьцааны гэрээ	999	425	574	14937.2	9051.3	5885.9
Бусад гэрээ	1	-	1	10.0	-	10.0
Лавлагаа, хуулбар	124	44	80	1064.0	367.0	697.0
Бүртгэлд өөрчлөлт оруулах	24	16	8	332.0	208.0	124.0

### **ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ**

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 3376.2 мян.мл зам талбай цэвэрлэж, 16.8 мян.ми хог тээвэрлэсэн байна. Өнгөрсөн оноос цэвэрлэсэн талбай 1072.5 мян/мл буюу 46.6 хувиар нэмэгдэж, харин тээвэрлэсэн хог 10.7 мян/ми буюу 38.9 хувиар буурсан байна. Ажил үйлчилгээний орлого 945.3 сая төгрөг болж өнгөрсөн оноос 633.2 сая төгрөг буюу 40.1 хувиар буурсан байна. Орлогын эх үүсвэрийг ангилвал 9.2 хувийг зам талбай, 40.9 хувийг гэр хорооллоос, 22.7 хувийг орон сууцнаас, 27.2 хувийг албан газраас тус тус олсон орлого эзэлж байна.

Хүснэгт 15. Тохижилтын ажил

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016.3	2017.3	Зөрүү	%
Цэвэрлэсэн талбай	мян.мл	2303.7	3376.2	1072.5	46.6
Тээвэрлэсэн хог	мян.ми	27.5	16.8	-10.7	38.9
Үүнээс:					
Орон сууц	мян.ми	6.9	4.2	-2.7	39.1
Гэр хороолол	мян.ми	12.4	7.6	-4.8	38.7
Албан газар	мян.ми	4.1	2.5	-1.6	39.0
Зам талбай	мян.ми	4.1	2.5	-1.6	39.0
<b>Ажил үйлчилгээний орлого</b>	<b>сая.төг</b>	<b>1578.5</b>	<b>945.3</b>	<b>-633.2</b>	<b>40.1</b>
Үүнээс:					
Зам талбай	сая.төг	291.0	86.9	-204.1	70.1
Гэр хороолол	сая.төг	579.4	386.3	-193.1	33.3
Орон сууц	сая.төг	321.9	214.6	-107.3	33.3
Албан газар	сая.төг	386.2	257.5	-128.7	33.3

## ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2017 оны 01 сарын байдлаар дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 81 өргөдөл, гомдол ирснээс 81-г хуулинд заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 16. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Ангилал	НИЙТ	Шийдвэрлэх шатандаа байгаа			Шийдвэрлэж хариу өгсөн		
		Хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд	Хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд
1800-1200 тусгай дугаарын утас	3	0	0	0	3	0	3
www.ub1200.mn цахим хуудас	1	0	0	0	1	0	1
Засгийн газрын 11-11 төв	4	0	0	0	4	0	4
Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв	18	0	0	0	18	0	18
Нутгийн захиргааны байгууллагууд	55	0	0	0	55	0	55
Smart UB аппликейшн, Clean UB аппликейшн	0	0	0	0	0	0	0
Мессеж	0	0	0	0	0	0	0
Шуурхай удирдлага, зохицуулалтын төв	0	0	0	0	0	0	0
<b>НИЙТ</b>	<b>81</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>81</b>	<b>0</b>	<b>81</b>



### ОСОЛ, ГЭМТ ХЭРЭГ

2017 оны 03 сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 1012 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор буурсан байна.



Хүснэгт 17. Гэмт хэрэг

Төрөл		Цагдаагийн I хэлтэст бүртгэгдсэн				Цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн			
		2016.03	2017.03	Илрүүлэл тийн хувь	Хувь	2016.03	2017.03	Илрүүлэл тийн хувь	Хувь
Хэргийн ангилал	Хөнгөн	204	194	59.4	-4.9	86	102	82.9	18.6
	Хүндэвтэр	148	143	49.5	-3.4	155	162	46	4.5
	Хүнд	18	22	81.8	22.2	8	10	100	25
	Онц хүнд	8	11	100	37.5	8			100
Гэмт хэргийн төрөл	Хүн амь		1			5			100
	Учрал	4	2		-50	3	9		2
	Залилан	68	80	64.8	17.6	16	7	66.7	-56.2
	Хүчин	1	2	100	100	1	2	100	100
	Танхай	17	17	100		11	16	93.3	45.4
	Булаалт	4	3	33.3	-25	3	1		-66.6
	Хулгай	136	121	44.7	-11	130	133	42	2.3
	ББМГУ	62	67	80	8.1	50	73	100	46
	Дээрэм	10	7	60	-30	7	6	66.7	-14.3
	ТХХАББАЖЗ	19	11	75	-42.1	12	3	100	-75
	Бусад	57	59	54.8	3.5	19	24		26.3
	<b>Бүгд</b>	<b>756</b>	<b>738</b>			<b>257</b>	<b>274</b>	<b>55.9</b>	<b>6.6</b>

**ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ**

Тус тасгийн алба хаагчдын гудамж замд хийсэн хяналт шалгалтаар 2017 оны 3-р сард нийт **7895** зөрчил илрүүлсэнээс Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27.1 дэх хэсгийн заалт зөрчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон **215**, мөн хуулийн 31.2.3, 32.2, 43.2, 52.1 дэх хэсгүүдэд заасан зөрчилтэй 48 тээврийн хэрэгслийг түр саатуулан журамлан Жолоочийн даатгалын тухай хуулийн 28.1.1 дэх хэсэгт заасан зөрчилтэй 0, улсын дугаарын хязгаарлалт **755**, бүрэн бус **269**, хамгаалах бүс хэрэглээгүй **902**, нийт **7234** жолоочийг **220.6** сая төгрөгөөр торгож ажиллав. Замын Цагдаагийн газар болон бусад албадаас зарлагдсан 16 дугаарыг илрүүлэн ерөнхий жижүүрт хүлээлгэн өгсөн. Цагдаагийн шалгах төхөөрөмж ашиглан 2013 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж ASAP санд бүртгэлтэй сэжигтэн яллагдагч тээврийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнд оролцож байсан 7, Цагдаагийн нийтлэг үүргээр 4 зөрчил тус тус илрүүлсэн.

**АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, ГАМШИГ**

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар хэлтсийн Гал унтраах, аврах 10 дугаар анги нь 85 удаагийн 2040 цагийн харуул ээлжийн үүрэг гүйцэтгэх явцад гал түймрийн дуудлагаар 196 удаа гарснаас 119 удаа гал түймэр дээр нийт 50 цаг 16 минут ажиллаж 265.3 тонн ус, шатах тослох материал дизель түлш 8.0 мянган литр буюу 13.3 сая төгрөгийг зарцуулан аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 2.4 сая төгрөгний өмч хөрөнгийг авран хамгаалж, 57 гал түймрийг иргэд унтрааж, 8 гал түймэр өөрөө унтарч, 49 байшин, барилга, 5 хүний амь насыг авран хамгаалсан байна.

## МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ


Тус хэлтэс нь 2017 оны 03 сарын байдлаар нийт 2207 нэгжид шалгалт, 396 нэгжид хяналт хийж гүйцэтгэсний 85.6 хувь нь ААНБ-г, 14.4 хувь нь иргэнийг хамарсан байна.

Хүснэгт 19. Хяналт, шалгалт, зөрчил, торгууль шийтгэвэрийн мэдээ, тасгаар


Үзүүлэлт		Нийт дүн	ЭМБХАБХ-ын тасаг	БОДБХНХХ-ын тасаг
Хяналт	ААНБ	227	219	8
	Иргэн	169	168	1
	Дүн	396	387	9
Шалгалт	ААНБ	2002	1317	685
	Иргэн	205	176	29
	Дүн	2207	1493	714
Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил	Нийт илэрсэн	840	765	75
	Арилгасан	406	378	28
Торгууль, шийтгэвэр	Тоо	100	87	13
	Үнийн дүн мян.төг	22610	16460	6150
Зөвлөн туслах сургалт, сурталчилгаа	ААНБ	126	85	41
	Иргэн	3	3	0
	Дүн	129	88	41

Энэ хугацаанд нийт 840 зөрчил илэрсний 406 буюу 48.4 хувийн зөрчлийг арилгасан ба нийт 100 торгууль, шийтгэвэрт нийт 22.61 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Зураг 12. Хийсэн хяналт тоо, тасгаар



Зураг 13. Хийсэн шалгалтын тоо, тасгаар





## СОЁЛ УРЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2017 оны 3 сарын байдлаар Чингэлтэй дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс:

- Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулж, 3272 хүүхэд багачууд, иргэд хамрагдсан байна.

Дүүргийн Засаг даргын 7 удаагийн захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэний асрах эрхийг хүчингүй болгосон, 1 хүүхдийг асран хамгаалагч харгалзан дэмжигчийг нь хүчингүй болгосон, 3 хүүхдийг асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоосон, 2 хүүхдийг асрамжийн төвд явуулсан.

## ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ

Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв нь 2017 оны 3-р сард нийт 375 хүн, 50 гэр бүлд хүрч ажилласан байна.

Хүснэгт 18. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалалын чиглэлээр хийсэн ажил

№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулагдсан ажил	Хамрагдсан хүний тоо
1	Хүүхдийн тусламжийн утас 108- аас	Ирсэн дуудлагын тоо 2-р сард- 18	18 хүүхэд
2	Ажилласан кейс	Нийт 21үүнээс: Бие махбодийн хүчирхийлэл-7 Бэлгийн хүчирхийлэл-2 Үл хайхрах хүчирхийлэл-5 Шинжээчийн дүгнэлт-2 Сэтгэл санааны хүчирхийлэл-1 Хүүхдийн эрхийн зөрчил-4 тус тус гарсан байна.	35 хүүхдийн эрхийг хамгаалан ажилласан.
3	Хүүхэд хамгааллын чиглэлээр	1.Хараа хяналтгүй хүүхдийн эрсдлийн программ дээр эрсдэлтэй гэж бүртгэгдсэн 10 хүүхдийн мэдээллийг шивж оруулсан.  2 Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэс, ДЗОУБ-ын Хайлааст ОНХХ-тэй хамтран “ <b>Хонх дарж, хаалга тогшье</b> ” хөдөлгөөн өрнүүлэн хүүхэд, гэр бүлийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд төр олон нийтийн байгууллагыг татан оролцуулах, олон нийтэд сурталчилан таниулж, хүчирхийлэл гэмт хэргээс сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулж эхлэсэн.  3. Иргэний хэргийн анхан шатны шүүхээс ирсэн гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамжийн асуудалтай	217 хүүхэд

		<p>иргэний хэрэг дээр 2 шинжээчийн баг томилогдон ажиллаж байна</p> <p>4. Сургалтаар Хорооны түвшинд ажиллаж буй хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах, Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиуд шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан түүнийг хэрэгжүүлэхэд дагалдан гарсан журмуудыг танилцуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, туршлага хуваалцах, кейс менежмент хийх, стресс бухимдлаа даван туулах аргачлал, арга зүйг өгөх зорилгоор зохион байгуулагдаж тус сургалтыг үндэсний хэмжээнд бэлтгэгдсэн сургагч багш нар мэргэжил, арга зүйгээр хангаж чадваржуулсан.</p>	
4	Гэр бүл, залуучуудын хөгжлийн чиглэлээр	<p>1. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын сурталчилах ажлын эхний үе шат 03 дугаар сарын 01-ний өдрөөс Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас эхлүүлж, ажлын төлөвлөгөө, удирдамж гарган ажиллаж байна.</p> <p>2. Хараа хяналтгүй хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зураглалтай болох санал авах хэлэлцүүлэгт Гэр бүл хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Адъяа оролцож өөрийн хэлтсийн хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтнүүдийн саналыг авч тусган саналаа НХГБХГ-т хүргүүлсэн.</p>	гэр бүл 50
5	Мэдээлэл судалгааны чиглэлээр	<p>Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/832 дугаар захирамж, Дүүргийн Засаг даргын “Бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн батлах тухай” А/148 дугаартай захирамж батлагдсан болно.</p> <p>Дээрх захирамжийн дагуу хэлтсийн Хөдөлмөрийн дотоод журам, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн гаргах ажлыг гүйцэтгэж байна.</p>	105



## СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ:

[WWW.1212.MN](http://WWW.1212.MN)

[WWW.UBSTAT.MN](http://WWW.UBSTAT.MN)

[WWW.CHINGELTEI.GOV.MN](http://WWW.CHINGELTEI.GOV.MN)

*Хянасан: Хэлтсийн дарга Д.МӨНХЗУЛ*



*Танилцуулга нэгтгэсэн:  
мэргэжилтэн Д. Ганзул*

И-мэйл хаяг: [chingeltei@nso.mn](mailto:chingeltei@nso.mn)

Хаяг: Улаанбаатар хот,

Чингэлтэй дүүрэг,

Нийслэлийн төр захиргааны

III байр 401 тоот

Утас: 70113013

70130767

11-310767